

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Ж.ЧИНБҮРЭН



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал суваг, дотоод сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн самбар зэрэгт байрлуулж олон нийтэд хүргэх	Салбарын хэмжээнд түгээсэн нийт мэдээлэл, контентын тоо	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Авлигатай тэмцэх газар
		1.2 Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах	Өдөрлөгийн үр дүн, оролцогчдын тоо	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Авлигатай тэмцэх газар
		1.3 Авлигын эсрэг хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах	Сургалтын үр дүн, тайлан, сургалтад оролцогчдын тоо	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Авлигатай тэмцэх газар

2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2.1 "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх	Журмын хэрэгжилтийн үнэлж, хэрэгжилтийг сайжруулахаар авсан арга хэмжээний дүн	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	
		2.2 Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн салбарын нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагуудыг үйл ажиллагааг нэмэгдүүлэх	Хамтран ажилласан мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагын тоо	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагууд, Авлигатай тэмцэх газар
		2.3 Эрүүл мэндийн салбарын мэргэжлийн нэгдсэн холбоог байгуулж замаар төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах	Мэргэжлийн нэгдсэн холбоонд орсон байгууллагын тоо	Эрүүл мэндийн яам	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, төрийн бус байгууллагууд
		2.4 Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	Ил тод нээлттэй мэдээлсэн мэдээллийн тоо	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	
		2.5 Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүнд суртал, ойлгомжгүй	Цахим шилжүүлсэн үйлчилгээний тоо	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	

		байдлыг арилгах зорилгоор цахим үйлчилгээг шинээр нэвтрүүлэх			
		2.6 Авлигатай тэмцэх газартай хамтран Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Эрүүл мэндийн яам болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв	Авлигатай тэмцэх газар
3	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	3.1 Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байхад байгууллагын удирдлагын баг тасралтгүй хяналт тавих, зөрчил үүссэн нөхцөл байдал яаралтай арга хэмжээ авч ажиллах	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	
		3.2 Салбарын хэмжээнд гарч буй өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нэгтгэн гомдлыг шалтгаан нөхцөлийг тодорхойлох	Салбарын өргөдөл гомдлын нэгдсэн тайлан, дүн шинжилгээ	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	
		3.3 Төгсөлтийн дараах сургалтын элсэлт, элсэлтийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж эрсдэлийг бууруулах	Хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан	Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төв	Авлигатай тэмцэх газар
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1 Эрүүл мэндийн байгууллага бүр авлигын эсрэг төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр тайлагнах	Төлөвлөгөөний биелэлт, тайлан	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагууд	
		4.2 Авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр	Хэрэгжүүлсэн шинэ санал, санаачилгын	Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл	

		байгууллагын удирдлага шинэ ажил санаачлан хэрэгжүүлж, сурталчлах	тоо, хэрэгжилтийн тайлан	мэндийн байгууллагууд	
		4.3 Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл шинээр олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчилж боловсруулах	Боловсруулсан судалгаа, мэдээлэл, эрх зүйн баримт бичиг	Эрүүл мэндийн яам болон Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар	

Хянасан:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Д.ОЧИРБАТ


ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА



Б.БАТБАЯР

Боловсруулсан:

ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ОДГЭРЭЛ